



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 230

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 15,120,000.00 (арван таван сая нэг зуун хорин мянган) төгрөгийн балансын үнэ бүхий 1 ширхэг автомашиныг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн захирал Б.Даваажав, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

000194F



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн  
230 дугаар тогтоолын хавсралт



Үйлдвэрлэл урлалын политехник коллежиин үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт  
балансаас балансад шилжүүлэх автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл ертөг (төгрөг)
1	Ниссан Х-трайл, 12-93 УНС, арал № Т30004218	2001/ 2008	15,120,000.00	15,120,000.00	0
	Нийт дүн		15,120,000.00	15,120,000.00	0